



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт                                     | Суурь түвшин | Зорилтот түвшин |                   | Биелэлт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | Хувь |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------|-------|------------------------------------------------------|--------------|-----------------|-------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                                                                                       |       |                                                      |              | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |      |
| ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ.<br>/“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө/ |                                                                                       |       |                                                      |              |                 |                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |      |
| ЗОРИЛТ1. ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА БАЙНА                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                       |       |                                                      |              |                 |                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |      |
| 1.1                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд өгөгдлийн шинжилгээ хийх                             | -     | Үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн тоо             | 2            | 1               | 1                 | Иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч нарын 2024 онд хийсэн бүртгэлд дүн шинжилгээ хийж 2025 оноос эхлэн 4 бүртгэгчийн ажил үүргийг сэлгэн ажиллуулсан байна.<br>Мөн сумдын улсын бүртгэгч нарын ажил үүргийг тэнцвэржүүлэх үүднээс бүртгэл хөтөлсөн өгөгдлийн шинжилгээ хийж, бүртгэл багатай Бугат, Буянт, Алтанцөгц, Толбо сумдын улсын бүртгэгч нарыг хуваарь гарган бүртгэлийн ачаалал ихтэй Өлгий суманд 8, 9 дүгээр саруудад ажиллуулсан.<br>Хэлтсийн нэгжийн зохион байгуулалтаар ХЭЭХУБТасгийн 4 улсын бүртгэгчээс 2 нь мэдүүлэг хүлээн авах, 2 нь боловсруулалт хийж, ажлын үүргийн хуваарийн дагуу сар сараар солигдон ажиллаж байна. Баяннуур, Булган, Сагсай сумдын улсын бүртгэгч нарт эд | 100% |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                                                                                       |       | Шинжилгээний үр дүнд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 2            | 1               | 1                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |      |

|                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                             |                                |                                                                        |       |       |       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |      |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------|------------------------------------------------------------------------|-------|-------|-------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
|                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                             |                                |                                                                        |       |       |       | хөрөнгийн эрхийн бүртгэл хөтлөх эрхийг 9 дүгээр сарын 20-иос нээж бүртгэл хөтлөх ажлыг эхлүүлсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |      |
| 1.2                                                                                                                                                                                                           | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байдалд хяналт тавих                                                                                     | -                              | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хувь                           | 99.8  | 100   | 100   | Тус хэлтэс нь Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сар бүр 90, жилийн турш 5, тухайн сар бүр 36 мэдээллээс нийт 131 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулан ажилласан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | 100% |
|                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                             | -                              | Тайлагнаж, байршуулсан мэдээллийн тоо                                  | 131   | 65    | 66    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |      |
| ЗОРИЛТ 2. ОРЧИН ҮЕИЙН ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЖ, ТӨРӨӨС ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ШУУРХАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ. |                                                                                                                                                             |                                |                                                                        |       |       |       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |      |
| 2.1                                                                                                                                                                                                           | Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин (Киоск)-ийн тоог нэмэгдүүлж, киоскоор үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх | -                              | Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /Киоск/-ны нэмэгдүүлсэн тоо  | 6     | 7     | 8     | 2025 онд ОНХС санхүүжилтээр Улсын бүртгэлийн үйлчилгээний /Киоск/ машин худалдан авч Сагсай, Баяннуур сумдын ЗДТГ-ын байранд байршуулан ажиллуулж байна. Аймгийн хэмжээнд Улсын бүртгэлийн үйлчилгээний киоск машин 2-оор нэмэгдэж нийт 7 машин ажиллаж байна. Киоскоор 5586 иргэнд үйлчилгээ үзүүлж нийтдээ 12309 үйлчилгээ авсан байна. 2025 оны ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ <a href="http://www.e-mongolia.mn">www.e-mongolia.mn</a> болон Хур-Дан нэг цонхны үйлчилгээний танхимд 24/7 Дөт машинаар иргэд олон нийтэд үйлчилгээ үзүүлж байна. | 100% |
|                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                             |                                | Киоскоор үйлчилгээ авсан иргэдийн тоо                                  | 6,723 | 4,000 | 6,000 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |      |
| 2.2                                                                                                                                                                                                           | “Улсын бүртгэлийн үйлчилгээний төв болон нэг цэг”-ийн үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх                                             | Төрийн болон төрийн бус байгуу | Улсын бүртгэлийн зөөврийн тоног төхөөрөмжөөр үзүүлсэн үйлчилгээний тоо | 20    | 10    | 30    | Тайлангийн хугацаанд 133 иргэнд зөөврийн тоног төхөөрөмжөөр улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | 100% |

|     |                                                                                                                                                    |                                      |                                                       |        |      |      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |      |
|-----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------|-------------------------------------------------------|--------|------|------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
|     |                                                                                                                                                    | ллагын<br>туслам<br>ж<br>дэмжлэ<br>г |                                                       |        |      |      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |      |
| 2.3 | Улсын бүртгэлийн байгууллагын 2025 оны үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх                                                                      | -                                    | Батлуулсан эрсдэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь    | -      | 98   | 100  | Улсын бүртгэлийн байгууллагын 2025 оны үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх төлөвлөгөөнд тусгуулахаар 3 удаагийн санал хүргүүлсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | 100% |
| 2.4 | Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд Улсын бүртгэлийн багц хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл санал боловсруулж хүргүүлэх | -                                    | Санал хүргүүлсэн тоо                                  | 2      | 2    | 3    | Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2025 оны ХЭГ/2252 дугаар албан бичгээр Улсын бүртгэлийн багц хууль, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд хэлтсийн албан хаагчдаас санал авч 4 удаа санал хүргүүлсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                           | 100% |
| 2.5 | Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх                                                                                                               | -                                    | Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн тоо | 56 748 | 2400 | 2500 | Цахим гарын үсгийн тухай хууль эцэслэн батлагдаж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Хуульд зааснаар Улсын бүртгэлийн байгууллага нь гэрчилгээжүүлэх байгууллага бөгөөд Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэнд 5 жилийн хугацаатайгаар тоон гарын үсгийг олгохоор тусгагдсан. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд Улсын бүртгэлийн байгууллагаас тоон гарын үсгийг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн иргэдэд олгож эхэлснээс хойш тус хэлтсээс 63531 иргэн тоон гарын үсгээ авчээ. Үүнээс гар утасны Gsign аппликейшинд 16434, иргэний үнэмлэхэд 50650 | 100% |

|     |                                                                                               |   |                                                    |        |        |        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |      |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------|---|----------------------------------------------------|--------|--------|--------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
|     |                                                                                               |   |                                                    |        |        |        | иргэн тус тус тоон гарын үсэг аваад байна.<br>Харин 2025 оны хувьд тайлант хугацаанд нийт 6783 иргэн тоон гарын үсэг авснаас Gsign аппликейшнд 6290, иргэний үнэмлэхэд 493 иргэн тус тус тоон гарын үсэг авсан.                                                                                                                                                                                                                                                                                                             |      |
| 2.6 | Улсын бүртгэлийн хууль тогтоомж, холбогдох журмын дагуу эрхлэн хөтөлнө                        | - | Иргэний улсын бүртгэл хөтөлсөн тоо                 | 31 456 | 10 500 | 11 000 | Тайлангийн хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/207 тоот тушаалаар шинээр батлагдсан “Иргэний улсын бүртгэл хөтлөх журам”-уудыг мөрдлөг болгон Иргэний улсын бүртгэлд тайлант хугацаанд нийт 23836 иргэн хамрагдсан. Тайлангийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд нийтдээ 8835 мэдүүлэг, онлайнаар 37 мэдүүлэг тус тус хүлээн авч хянан шийдвэрлэсэн байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 733 бүртгэл хөтөлсөн байна | 100% |
|     |                                                                                               |   | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлсөн тоо     | 10 701 | 3 000  | 3100   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |      |
|     |                                                                                               |   | Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлсөн тоо       | 1320   | 200    | 350    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |      |
| 2.7 | Үндэсний энгийн цахим гадаад паспортын үйлчилгээг сумаасаа үзүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах | - | Сумаас гадаад паспорт захиалж авсан иргэдийн тоо   | 1320   | 500    | 700    | Нийт 5776 гадаад паспорт бүртгэл хөтөлснөөс 1377 иргэн сумдаас үндэсний энгийн гадаад паспортын үйлчилгээ авсан байна. Тус аймгийн анхан шатны нэгж болох 13 сум 1 тосгон, иргэний бүртгэлийн тасгийн 4 улсын бүртгэгч нарт гадаад паспортын бүртгэл хөтлөх эрхийг нээж, улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн                                                                                                                                                                                                         | 100% |
|     |                                                                                               |   | Зураг авах тоног төхөөрөмжөөр хангагдсан сумын тоо | -      | 6      | -      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |      |

|                                                                                                                           |                                                                                                                         |   |                                                             |      |     |     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |      |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|-------------------------------------------------------------|------|-----|-----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
|                                                                                                                           |                                                                                                                         |   |                                                             |      |     |     | шуурхай хүргэх боломжийг бүрдүүлсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |      |
| 2.8                                                                                                                       | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia, E-business/ -аар үзүүлэх бүртгэлийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх | - | Цахимаар үзүүлсэн улсын бүртгэлийн тоо                      | 2200 | 200 | 300 | <a href="http://www.e-mongolia.mn">www.e-mongolia.mn</a> веб сайтаар захиалсан гадаад паспорт 34, иргэний цахим үнэмлэх 470 ширхэг хэвлэгдэн ирж иргэдэд олгогдоод байна. МИК-иас барьцааны гэрээ дуусгавар болгох 35 бүртгэлийг онлайнаар бүртгэж баталгаажуулсан.                                                                                                                                                                                                 | 100% |
| 2.9                                                                                                                       | Улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах                                                                         | - | Иргэний улсын бүртгэлийн баримтыг цахимжуулсан тоо          | 1000 | 500 | 500 | Тайлант хугацаанд 13497 бүртгэлийн 34271 хуудас материалыг цахимжуулсан байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | 100% |
| 2.10                                                                                                                      | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах                                                  | - | Хэвлэл мэдээлэл болон цахимаар олон нийтэд сурталчилсан тоо | 32   | 2   | -   | Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн Дотоод хяналт шалгалт хийх тухай А/26 дугаар тушаалын дагуу тус хэлтэст хийсэн Хяналт шалгалтын албан шаардлагын хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 07-нд бүртгэлийн зөрчлийг хэрхэн арилгаж буй байдалд хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах тухай арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгч, дахин зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, бүртгэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан. | 100% |
| ЗОРИЛТ 3. УЛСЫН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НЭГДСЭН САНГИЙН НУУЦЛАЛЫГ ХАНГАН, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ. |                                                                                                                         |   |                                                             |      |     |     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |      |
| 3.1                                                                                                                       | Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих замаар улсын бүртгэлийн үнэн зөв байх                         | - | Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.           | 100  | 40  | 60  | Тус хэлтсийн хяналтын улсын байцаагч нь 2025 онд давхардсан тоогоор нийт 16133 бүртгэлд                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | 100% |

|  |                                                                            |  |  |  |  |  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |  |
|--|----------------------------------------------------------------------------|--|--|--|--|--|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|
|  | зарчмыг хангахад чиглэсэн төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах |  |  |  |  |  | <p>байнгын хяналт тавьж шалгасан байна. Үүнээс:</p> <p>Иргэний улсын бүртгэлийн 4967 бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 4862 бүртгэл, хуулийн этгээдийн 2390 бүртгэл, улсын бүртгэлийн архивын чиглэлээр 2753 бүртгэлийн эх нотлох баримтад байнгын хяналт тавьж шалгасан. Илрүүлсэн зөрчлийг ангилж үзвэл:</p> <p>Иргэний улсын бүртгэл 165,<br/>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 160,<br/>Хуулийн этгээдийн улсын бүртгэл 127,<br/>Архивын зөрчил 49-ийг тус тус илрүүлсэн.</p> <p>Илрүүлсэн зөрчлийн хүрээнд 122 хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 2535 иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд холбогдох эрх зүйн нөхцөл байдлыг эх нотлох баримтыг үндэслэж тогтоон шийдвэрлэж, зөрчлийг арилгасан. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт 9, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 165, гүйцэтгэлийн хяналт шалгалт 10 хийж илрүүлсэн зөрчилд тэмдэглэл үйлдэж, зөрчил арилгуулах тухай 6 албан шаардлагыг хэлтсийн /ахлах/ улсын бүртгэгч нарт хүргүүлэн,</p> |  |
|--|----------------------------------------------------------------------------|--|--|--|--|--|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|

|     |                                                                                                                                                                              |             |                                           |            |             |             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |      |
|-----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-------------------------------------------|------------|-------------|-------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
|     |                                                                                                                                                                              |             |                                           |            |             |             | зөрчил арилгах арга хэмжээг авч ажилласан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |      |
| 3.2 | Улсын бүртгэлийн байгууллагын компьютер, түүний дагалдах техник тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэн, сайжруулах                                                        | Улсын төсөв | Техник, тоног төхөөрөмжийн шинэчилсэн тоо | 3          | 3           | 4           | Азийн хөгжлийн банкны Техникийн туслалцааны дэмжлэгтэйгээр “Сумдад эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах, нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах” төслийг 2024 оноос амжилттай хэрэгжүүлж байна. Төслийн нэгжээс 2025.02.07-ны өдөр улсын бүртгэлийн үйлчилгээний дэд бүтцийг сайжруулах зорилтын хүрээнд байгууллагад 1 ширхэг иж бүрэн компьютер, 1 ширхэг скайнер, 1 ширхэг принтер зэрэг 3 төрлийн техник, тоног төхөөрөмжийг хүлээн авсан. | 100% |
| 3.3 | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах, тайлагнах, байршуулах, санхүүгийн дотоод аудитыг хэрэгжүүлэх | -           | Зөвлөмж, акт, албан шаардлагын тоо        | 0          | -           | -           | Хэлтсийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэж “Зөрчилгүй” дүгнэлт авсан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох дансны мэдээллүүдийг тухай бүр 100, сар бүр 40, хагас жилээр 4, жил бүр 5 удаа тус тус хуульд заасан хугацаанд оруулж ажиллав.<br><br>Төсөв, санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангах, байгууллага, иргэдэд нээлттэй                                                                                                                                         | 100% |
|     |                                                                                                                                                                              |             | Тайлагнасан мэдээллийн мөнгөн дүн         | 1146136795 | 599.134.600 | 547.002.195 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |      |



|                                                                                                                                     |                                                                                               |   |                                                                                                                                    |               |              |   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |      |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------|---|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|--------------|---|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
|                                                                                                                                     |                                                                                               |   |                                                                                                                                    |               |              |   | байлгах ажлын хүрээнд байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудсанд 2025 оны төсөв, орлого, зарлага, төсвийн байгууллагын санхүүжилтын сарын мэдээг хуульд заасан хугацаанд шилэн дансанд байршуулсан.                                                                                                                                                                                                                                                                                                                          |      |
| 3.4                                                                                                                                 | Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцлийг сайжруулах                                  | - | Устгаж үгүй болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 1951-1956 он хүртэлх бүртгэлийн журналыг сканнерлэж, файл болгосон журналын тоо | -             | 2            | 3 | Архивын эх нотлох баримт болох иргэний бүртгэлийн журналыг скайнердэж цахимжуулах ажлын хүрээнд Иргэний гэр бүлийн бүртгэлийн 1951-1952 оны журналуудыг сканнерлэж, файл үүсгэж хадгалсан.                                                                                                                                                                                                                                                                                                                                       | 100% |
| ЗОРИЛТ 4. ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭН, ГАДААД ОРНЫ БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУРШЛАГААС БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГТ ТОХИРУУЛАН ХЭРЭГЖҮҮЛНЭ. |                                                                                               |   |                                                                                                                                    |               |              |   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |      |
| 4.1                                                                                                                                 | Аймаг сумдын ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах | - | Шийдвэрлүүлсэн хөрөнгийн хэмжээ мөнгөн дүн                                                                                         | 108,0 сая.төг | 13,8 сая.төг | - | Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймаг, сумын хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах зорилгоор Аймгийн Засаг дарга Е.Зангартай хэлтсийн 2025 онд Хамтран ажиллах үр дүнгийн гэрээг байгуулав.<br>Мөн гэрээнд талуудын хүлээх үүрэг, улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт, төлбөрийн нөхцөл, хэрэгжилтийг дүгнэх, үнэлэх журмуудыг тусгаж, хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний тоо хэмжээ, чанарын | 100% |
|                                                                                                                                     |                                                                                               |   | Уулзалт зохион байгуулсан тоо                                                                                                      | 9             | 2            | 1 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |      |

|                                                          |                                                                                            |   |                            |     |    |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |      |
|----------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------|---|----------------------------|-----|----|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
|                                                          |                                                                                            |   |                            |     |    |    | шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тодорхойлсон юм. Үүний үр дүнд Булган, Цэнгэл, Алтай, Дэлүүн, Ногооннуур, Баяннуур сумдын гадаад паспортын бүртгэлийн үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангуулах зорилгоор Орон нутгийн хөгжүүлэх сангаас зургийн аппарат 6ш нийт 13.600.000 төгрөг, Цахим засаглалын хүрээнд Сагсай сум улсын бүртгэлийн ДӨТ /киоск/ машин 23.000.000 төгрөг, Баяннуур сум улсын бүртгэлийн ДӨТ /киоск/ машин 25.000.000 төгрөг нийт 56,800,000 /тавин зургаан сая найман зуун мянга/ төгрөгийн санхүүжилтийг орон нутаг хөгжүүлэх сангаас шийдвэрлүүлсэн. |      |
| ЗОРИЛТ 5. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛНЭ |                                                                                            |   |                            |     |    |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |      |
| 5.1                                                      | Хэлтсийн 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэн ажиллах. /2.6.2.3./ | - | Хэрэгжилтийг хангасан хувь | 100 | 40 | 60 | Авилгатай тэмцэх газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Төрийн албаны зөвлөлийн талаар анхааруулга, санамж материалыг байгууллагын Пэйж хуудас болон албан хаагчдын группт байршуулан ажиллаж байна.<br><br>Авилгатай тэмцэх газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Төрийн албаны зөвлөлийн талаар анхааруулга, санамж материалыг байгууллагын Пейж хуудас болон албан хаагчдын                                                                                                                                                                                                       | 100% |

|     |                                                                                                                                         |   |                                                                                                                     |   |    |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |      |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------|---|----|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
|     |                                                                                                                                         |   |                                                                                                                     |   |    |    | <p>группт байршуулан ажиллаж байна.</p> <p>“Авлигын эсрэг нэгдье, Шударга нийгэм- Биднээс эхэлнэ” гэсэн шинээр гарсан пострыг хэлтийн пейж хуудас болон мэдээллийн самбард байршуулсан ба сумдын улсын бүртгэлийн мэдээллийн буланд давхар байршуулан ажиллаж байна.</p>                                                                                                                                                                                                                                                                                                     |      |
| 5.2 | Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, ашиг хүртэгчийн мэдээллийг нээлттэй мэдээллийн стандартаар ил тод болгож, тогтмол шинэчлэх /4.3.1.2./ | - | Нээлттэй мэдээллийн стандартаар ил тод болгосон хуулийн этгээдийн хувь                                              | 0 | 40 | 60 | <p>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ХХК цахимаар болон биечлэн ирж хэрхэн бүртгүүлэх талаар фэйсбук, сошиал сүлжээгээр олон нийтэд түгээн ажилласан.</p> <p>Мөн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, төрийн бус байгууллагын тайлан, санхүүгийн тайлангаа гаргаж холбогдох байгууллагад илгээгээгүйн улмаас улсын бүртгэлээс хасагдах жагсаалтад орсон хуулийн этгээдийн талаар орон нутгийн радиод 2 удаа ярилцлага мэдээлэл өгсөн. Түүнчлэн хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх эрх нээлгэсэн сумдын улсын бүртгэгч нарыг чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулсан.</p> | 100% |
| 5.3 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх                            | - | АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим | 5 | 1  | 2  | <p>Тайлангийн хугацаанд Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлж хэлтсийн албан хаагч болон иргэд олон нийтэд олон нийтийн радио, тв гээр</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | 80%  |

|                                                                                    |                                                                                     |   |                                                                                                                                 |   |   |   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |      |
|------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---|---|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
|                                                                                    |                                                                                     |   | ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо |   |   |   | дамжуулан 6 удаа мэдээлэл өгч, 4 удаа сурталт зохион байгуулж, АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд 15 удаа хүргэсэн болно. Албан хаагч нарын албаны өрөөний хаалганд, үйлчилгээ үзүүлдэг цонхонд Төрийн үйлчилгээний хүнд суртлыг товч мэдээлнэ үү гэсэн стикр хаяг нааж байршуулав. Тус хэлтсийн албан ёсны цахим хуудас <a href="https://bayan-ulqii.burtgel.gov.mn/">https://bayan-ulqii.burtgel.gov.mn/</a> нийгмийн сүлжээний <a href="https://www.facebook.com/bayanulqii6burtgel">https://www.facebook.com/bayanulqii6burtgel</a> пэйж хуудас болон хэлстийн үйлчилгээний танхимд байрлах самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах буланг ажиллуулж, мэдээллийг тогтмол шинэчилж хэвшсэн. |      |
| ЗОРИЛТ 6. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ. |                                                                                     |   |                                                                                                                                 |   |   |   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |      |
| 6.1                                                                                | Эцсийн өмчлөгчийн мэдээллийн чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулах /зорилт 5.7/ | - | Албан хаагчдыг чадавхижуулах сургалт зохион байгуулсан тоо                                                                      | 0 | 1 | - | 2025 онд Булган, Баяннуур сумдад хуулийн этгээдийн бүртгэлийг хөтлөх эрхийг нээж, хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх, нэрийн баталгаажуулалт, эцсийн өмчлөгчийн талаарх танхимаар дадлагуулах сургалт хийж, алслагдсан сумдын                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | 100% |

|                                                                                                         |                                                                                                                                                        |   |                                                            |     |    |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |      |
|---------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|------------------------------------------------------------|-----|----|----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
|                                                                                                         |                                                                                                                                                        |   |                                                            |     |    |    | иргэдэд бүртгэлийн үйлчилгээг сумаасаа авах боломжоор хангалаа.<br>Хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх эрх нээлгэсэн сумдын улсын бүртгэгч нарыг чадавхжуулах сургалтыг 4 удаа зохион байгуулж, эцсийн өмчлөгчийг хэрхэн бүртгэх талаар мэдээлэл өгч ажилласан. Холбогдох сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр цахимаар, 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр танхимаар зохион байгуулсан. |      |
| 6.2                                                                                                     | Кибер аюулгүй байдлын тухай хууль, Мөнгө угаах, терроризмтой тэмцэх үндэсний зөвлөлийн зөвлөмж болон бусад бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэн ажиллах | - | Албан хаагчдыг чадавхижуулах сургалт зохион байгуулсан тоо | 0   | 1  | -  | Албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх кибер аюулгүй байдал” сэдэвт сургалтыг аймгийн Цагдаагийн газартай хамтран зохион байгуулж цагдаагийн ахмад М.Жанарыс алба хаагч нарт мэдээлэл өгөв.<br>"ЦАХИМД ЗӨВ БАЙЯ" уриатай КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ, мэдээллийг хэлтсийн цахим хуудаст байршуулан олон нийтэд түгээн сурталчлан ажилласан.          | 100% |
| ЗОРИЛТ 7. ЧАДАХУЙН ЗАРЧИМД СУУРИЛСАН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЖ, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАНА. |                                                                                                                                                        |   |                                                            |     |    |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |      |
| 7.1                                                                                                     | Байгууллагын 2025 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх                                                                               | - | Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь                    | 100 | 50 | 50 | 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр иргэний улсын бүртгэлийн тасгийн төвийн улсын бүртгэгч болон сумдын улсын бүртгэгч нарт “Биеийн давцахгүй өгөгдлийн бүртгэлд гарч буй зөрчил, цаашид анхаарах асуудал” сэдэвт сургалт, иргэн                                                                                                                                                               | 100% |

|     |                                                                                                                                                         |   |                                                               |   |    |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |     |
|-----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------------------------------------------------|---|----|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
|     |                                                                                                                                                         |   |                                                               |   |    |    | хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр шинээр томилогдсон болон сэлгэн ажиллаж байгаа албан хаагчдад Улсын бүртгэлийн хууль тогтоомж, бүртгэл хөтлөх журам, бүртгэлийн материалын бүрдлийг нягтлах, бүртгэх талаар 5 удаагийн сургалт, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай холбогдох эрх зүйн 5 удаагийн сургалтыг хяналтын улсын байцаагч нар тус тус танхим болон цахимаар сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байна. Аймгийн прокурорын газраас эрх бүхий албан хаагч нарт зориулсан 2 удаагийн зөвлөгөөн, 5 удаагийн сургалт, Авилгатай тэмцэх газрын 1 удаагийн сургалт, Цагдаагийн газрын 2 удаагийн сургалтад алба хаагч нар танхимаар хамрагдсан. |     |
| 7.2 | Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлж эхлэх | - | Албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлсөн хувь | - | 40 | 50 | Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс албан бичиг, хурлын тэмдэглэл болон тушаалыг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлж хэвшсэн. УБЕГ-аас ирүүлсэн 2025 оны 09 сарын 25-ны өдрийн 2-3/11116 тоот албан бичигт дурьдсан “Хичээл үзэж судлах тухай” үүрэг даалгаврын дагуу тус хэлтсийн                                                                                                                                                                                                                                                                                                                                            | 90% |

|     |                                                                                                                                 |   |                                                   |   |    |   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |     |
|-----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------------------------------------|---|----|---|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
|     |                                                                                                                                 |   |                                                   |   |    |   | 26 албан хаагч Удирдлагын академийн сургалтын нэгдсэн платформ /surgalt.gov.mn/-д байршуулсан Монгол бичгийн анхан болон дунд шатны хичээлийг бие даан үзэж дуусган сертификат авсан ба биелэлтийг илтгэх хуудсаар УБЕГ-т хүргүүлсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |     |
| 7.3 | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/110 дугаар тушаалаар баталсан “Хамгийн чухал нь” зорилтоот арга хэмжээг хэрэгжүүлэх | - | Үзлэг, онолшилгоонд алба хаагчдын хамрагдсан хувь | - | 70 | - | Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачилгаар салбарын хөдөө орон нутагт ажиллаж буй алба хаагчид болон тэдний гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, эрт илрүүлэг хийх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилго бүхий “Хамгийн чухал нь” зорилтот арга хэмжээний хүрээнд Баян-Өлгий аймгийн Хилийн цэргийн 0165 дугаар ангийн эрүүл мэндийн төвд 2025 оны 04 сарын 15-21-ний өдрийн хооронд эрүүл мэндийн үзлэг зохион байгуулагдсан. Уг эрүүл мэндийн үзлэгт тус хэлтсийн 25 албан хаагч, албан хаагчдын гэр бүлийн гишүүд 3, улсын бүртгэлийн ахмад албан хаагчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн хамт 4, нийт 32 хүн 6 үзүүлэлтээр үзлэг шинжилгээнд хамрагдсан.<br>Ховд аймгийн Баруун бүсийн оношлогооны төв болон Улаанбаатар хотод эмнэлгийн | 70% |

|             |  |  |  |  |  |  |                                                                                                                                             |       |
|-------------|--|--|--|--|--|--|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|
|             |  |  |  |  |  |  | нарийн шинжилгээний үзлэгт хамрагдаж хагалгаанд орсон 2 албан хаагчид дундын хуримтлалын сангаас 200.000 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. |       |
| Ерөнхий дүн |  |  |  |  |  |  |                                                                                                                                             | 97,6% |

*Төлөвлөгөөг үнэлсэн:*

**Төсвийн шууд захирагч**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга  
(албан тушаал)

..... / Д.Давааням /  
(гарын үсэг)  
(огноо)  
.....

*Тэмдэг*

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:*

**Нэгжийн дарга**

Хууль зүй, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга  
(албан тушаал)

..... / Э.Ганбат /  
(гарын үсэг)  
(огноо)  
.....

*Тайлагнасан:*

**Нэгжийн дарга**

Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга  
(албан тушаал)

..... / Д.Мягмаржав /  
(гарын үсэг)  
(огноо)  
.....